МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 26 өдөр Дугаар А/125 Мөрөн сум

Газар эзэмших эрх дуусгавар болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Засгийн газрын 2024 оны 32 дугаар тогтоолын 13 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/189 дүгээр захирамжаар газар эзэмшигч байгууллага "Хөвсгөл аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар" (РД:9070656)-ын Мөрөн сум 13 дугаар баг 6712017901 нэгж талбарын дугаартай төрийн захиргааны байгууллагын зориулалтаар эзэмшүүлсэн 10739м^2 газрын газар эзэмшигч "Хөвсгөл аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар" нь газар эзэмших эрхийн гэрчилгээ, гэрээгээ цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу газар эзэмших эрхийг нь дуусгавар болгож нийтийн эзэмшилд шилжүүлсүгэй.

2.Уг захирамжаар газар эзэмшиж байсан газар эзэмшигч байгууллага "Хөвсгөл аймгийн хүнс хөдөө аж ахуйн газар"-ын 0000185324 дугаартай газар эзэмших эрхийн гэрчилгээ, аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн А/189 дүгээр захирамжийн холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгож газар эзэмшигчийн мэдээллийн сангаас хасалт хийхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д зөвшөөрсүгэй.

3.Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

4.Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010373